

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ,
НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОА-2023/51-8-ШТА-НА

Чойбалсан хот 2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

| | |
|---|---|
| Товчилсон үгийн тайлбар..... | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл..... | 4 |
| 1. ЧОЙБАЛСАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, НЭР ДЭВШИГЧ ХАНДИВ АВААГҮЙ БАЙНА..... | 5 |
| 1.1 Нөхөн сонгуульд оролцсон хоёр нэр дэвшигчийн дансанд орлого ороогүй, зарлага гараагүй байна..... | 5 |
| 1.2 Мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна..... | 5 |
| 2. ЧОЙБАЛСАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНАСАН БАЙНА..... | 6 |
| 2.1 Хуулиар зөвшөөрөөгүй хандив аваагүй байна..... | 6 |
| 2.2 Сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан байна...6 | 6 |
| ДҮГНЭЛТ:..... | 6 |
| ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:..... | 7 |

Товчилсон үгийн тайлбар

| | |
|------|------------------------------|
| НА | Нийцлийн аудит |
| ТАБ | Төрийн аудитын байгууллага |
| ШТА | Шууд тайлагнах аудит |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| МАН | Монгол ардын нам |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

| | |
|---|---|
| Аудит хийх үндэслэл, бүрэн эрх | Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж нийтэд мэдээлнэ.</p> |
| Аудитын зорилт | Чойбалсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ. |
| Аудитын хамарсан хүрээ | Аудитад нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн бүрдүүлсэн орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан, эрх бүхий байгууллагаас гаргасан лавлагаа мэдээлэл, арилжааны банкнуудаас ирүүлсэн нэр дэвшигчдийн хандивын дансны хуулга, сонгуулийн зардлын тайланд аудитын хуулийн этгээдийн гаргасан дүгнэлт зэрэг шаардлагатай эх сурвалжийг хамруулсан. |
| Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт | Аудитын ажлыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг үндэслэн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 15 дугаар тушаалаар баталсан “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох тухай”, УАГ-ын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 06/307 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянан, холбогдох байгууллагууд болон аудит хийсэн хуулийн этгээдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан журам, заавар, аргачлалын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт гарган тайланг бэлтгэв. |
| Үндсэн мэдээлэл | Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарийг Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан байна. Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2023 оны 06 дугаар сарын 18 байхаар товлон зарлаж, зохион байгуулсан байна. Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуульд МАН-аас хоёр иргэн нэр дэвшиж оролцсон байна. |
| Аудитын бүрэлдэхүүн, хугацаа | Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, аудитор М.Ганбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн. |

1. ЧОЙБАЛСАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, НЭР ДЭВШИГЧ ХАНДИВ АВААГҮЙ БАЙНА

1.1 Нөхөн сонгуульд оролцсон хоёр нэр дэвшигчийн дансанд орлого ороогүй, зарлага гараагүй байна

Дорнод аймгийн Чойбалсан сумын 2023 оны нөхөн сонгуульд МАН-аас хоёр иргэн нэр дэвшиж оролцсон байна. Үүнд:

Хүснэгт 1. Нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн судалгаа

| д/д | Намын нэр | Чойбалсан сумын ИТХ-ын 2023 оны нөхөн сонгууль | Нийт нэр дэвшигчийн тоо |
|-----|------------------|--|-------------------------|
| 1 | Монгол ардын нам | 2 | 2 |
| | Нийт | 2 | 2 |

Эх сурвалж: Нэр дэвшигчдийн ирүүлсэн тайлан

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарийг Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу нэр дэвшигчид аудитын хуулийн этгээдээр сонгуулийн зардлын тайландаа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулан 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 07 дугаар албан бичгээр Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Нөхөн сонгуульд оролцсон хоёр нэр дэвшигчийн дансанд орлого ороогүй, зарлага гараагүй байна.

1.2 Мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 “Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн, дахин сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу хандивын тайлангаа төрийн аудитын байгууллагад ирүүлж дүгнэлт гаргуулсан байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаар мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна.

2. ЧОЙБАЛСАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНАСАН БАЙНА

2.1 Хуулиар зөвшөөрөөгүй хандив аваагүй байна

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 15 дугаар тушаалаар баталсан Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоосныг 2 нэр дэвшигч хэтрүүлээгүй байна. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив аваагүй байна.

2.2 Сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан байна

Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуульд МАН-аас оролцсон нэр дэвшигчид зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан бөгөөд тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлсэн гэсэн 2 дүгнэлт гарсан байна.

Аудитын хуулийн этгээд нь Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд аудит хийж баталгаажуулсныг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар дахин хянахад алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуульд МАН-аас нэр дэвшиж оролцсон Буджав овогтой Анхзаяа, Төмөрбаатар овогтой Туул нарын сонгуулийн зардлын тайлан нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/27

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг УАГ-ын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланг нийтэд мэдээлж ажиллахыг аудитор М.Ухаанбилэгт даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010071

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN